



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО**

**“Коронавируст халдвар/ковид-19/-н үед спортын төрлийн  
үйл ажиллагаанд үүсэх эрсдэл, түүнээс хэрхэн сэргийлэх  
талаархи мэдээлэл**

2021.02.25



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО**

## **КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ТАРХАЛТЫН ТҮВШИНГ ТОГТООЖ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ**

Хоёр.Халдварын тархалтын түвшин

- 2.1.2. “Шар түвшин” (зөөвөрлөгдсөн, алаг цоог тархалттай):

Шалгуур үзүүлэлт: -Сүүлийн 14 хоногийн хугацаанд бүртгэгдсэн болон зөөвөрлөгдөн ирсэн тохиолдол нь цаг хугацаа, газар зүйн байршил, тархвар судлалын хувьд хоорондоо холбоогүй байх.



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО**

## **КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ТАРХАЛТЫН ТҮВШИНГ ТОГТООЖ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ**

- Дөрөв.Халдварын тархалтын түвшинд хэрэгжүүлэх үйл ажиллагаа
- 4.3. “Шар болон Улбар шар түвшин”-д “Гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэг”-т нутаг дэвсгэрийн хэмжээнд бүрэн эсхүл хэсэгчилсэн байдлаар шилжүүлж, төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд тодорхой хүрээнд хорио цээрийн болон хязгаарлалтын дэглэм тогтооно.
- 4.5. Халдварын тархалтын түвшин бүрт төрийн байгууллага, хүн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг энэ журмын хавсралтад заасан горимоор зохицуулна.
- 4.6. Төрийн байгууллага, хүн, хуулийн этгээд нь энэ журмын хавсралтад заасан горимын дагуу үйл ажиллагаа явуулахдаа “Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах түр журам”-ыг мөрдөж, тусгай нөхцөл, шаардлагыг биелүүлж ажиллана.



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО**

## **КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ТАРХАЛТЫН ТҮВШИНГ ТОГТООЖ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ**

Хориглосон үйл ажиллагаа:

- 1. Уралдаан тэмцээн;
- 2. Аялал зугаалга (гэр бүлээс бусад);
- 3. Өргөтгөсөн болон үзэсгэлэн худалдаа;
- 4. Баар (диско);
- 5. Цахим тоглоомын газар, Хүүхдийн тоглоомын төв.



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО**

## **КОРОНАВИРУСТ ХАЛДВАР (КОВИД-19)-ЫН ТАРХАЛТЫН ТҮВШИНГ ТОГТООЖ, ТӨРИЙН БАЙГУУЛЛАГА, ХҮН, ХУУЛИЙН ЭТГЭЭДИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААГ ЗОХИЦУУЛАХ ТҮР ЖУРАМ**

Ажлын горим:

- Нэг дор 30-аас дээш хүн цугларахгүй байх (2 метрээс доошгүй зай барих)

Ажлын байрны горим:

- Халдвар хамгааллын дэглэм сахих;
- “QR” код байршуулан ажилтан, албан хаагч, үйлчлүүлсэн иргэдийг бүртгэх.



**ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО**



**ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
БИЕЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРООНЫ  
ДАРГЫН ТУШААЛ**

2021 оны 02 сарын 23 өдөр

Дугаар А/21

Улаанбаатар хот

**Удирдамж батлах тухай**

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27<sup>1</sup> дугаар зүйлийн 27<sup>1.4</sup>, Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.4 дэх заалт, Засгийн газрын 2021 оны 45 дугаар тогтоол, Улсын онцгой комиссын даргын 2021 оны 18 дугаар тушаалыг тус тус үндэслэн ТУШААХ НЬ:

1. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг нэгдүгээр хавсралтаар, нэгдсэн төлөвлөгөөг хоёрдугаар хавсралтаар, Биеийн тамир, спорт, чийрэгжүүлэлт, бялдаржуулах чиглэлийн үйл ажиллагаанд мөрдөх удирдамжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.
2. Удирдамжийг хэрэгжүүлж ажиллахыг Аймаг, нийслэл, дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороо, төрийн үйлчилгээний болон төрийн өмчит аж ахуйн нэгж байгууллагад тус тус үүрэг болгосугай.
3. Тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Биеийн тамир, спортын улсын хорооны дэд дарга /Ц.Одонбаяр/-д даалгасугай.

ДАРГА

Ц.ШАРАВЖАМЦ



Биеийн тамир, спортын улсын хорооны даргын 2021 оны 02 дугаар сарын 23 өдрийн А/21 тушаалын гуравдугаар хавсралт



**БИЕЙН ТАМИР, СПОРТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНД  
"КОРОНАВИРУСТ ХАЛДВАР /КОВИД-19/-ААС СЭРГИЙЛЭХ  
АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ УДИРДАМЖ**

**Нэг. Нийтлэг үндэслэл**

1.1. Энэхүү удирдамжийн зорилго нь Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, урьдчилан сэргийлэх Биеийн тамир, спортын үйлчилгээ үзүүлдэг төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагаанд халдвар хамгааллын дэглэм сахиулах, ажил үйлчилгээг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

1.2. Халдвар хамгааллын дэглэм сахиулах үйл ажиллагаанд хууль дээдлэх, биеийн тамир, спортын байгууллага, иргэн, хуулийн этгээдийн үйл ажиллагааг тухайн нөхцөлд тохируулан, эрүүл аюулгүй орчинд амьдрах нөхцөлийг хангах зарчим баримтална.

1.3. Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх, Биеийн тамир, спортын үйл ажиллагаа нь тухайн нутаг дэвсгэрийн халдвар тархалтын түвшин, нийгэм, эдийн засгийн бусад нөхцөл байдалд үндэслэнэ.

**Хоёр. Удирдлага зохион байгуулалт**

2.1 Улсын онцгой комиссын даргын 2021 оны 18 дугаар тушаалын хавсралт "Коронавируст халдвар (КОВИД-19)-аас сэргийлэх түр журамд заасан /1-7 дугаар зүйл/ 6 дугаар хавсралтад тусгасан ерөнхий болон тусгай нөхцөл шаардлагыг чанд мөрдөн хэрэгжүүлж ажиллах;

2.2 Аймаг, нийслэлийн Биеийн тамир, спортын салбарын төрийн байгууллага нь тухайн нутаг дэвсгэр үйл ажиллагаа эрхэлж байгаа чийрэгжүүлэх, бялдаржуулах төв, төрөлжсөн спорт клуб, заал, талбай, цанын бааз, мөсөн гулгуурын талбайн тоо, хүний нөөцийн судалгааг гаргаж Биеийн тамир спортын улсын хороонд хүргүүлэх;

2.3 Тухайн нутаг дэвсгэр дэх биеийн тамир, спортын арга хэмжээ, ажил үйлчилгээг зохион байгуулахад коронавируст халдвараас урьдчилан сэргийлэх үйл ажиллагааг хэрэгжүүлэх, хяналт тавих чиг үүрэг бүхий салбар ажлын хэсэг /цаашид салбар ажлын хэсэг гэх/ байгуулж ажиллах гишүүдийн мэдээллийг дээд шатны байгууллагад хүргүүлэх;

2.4 Салбар ажлын хэсэг нь хуваарийн дагуу хяналт тавьсан тайлан мэдээг хүснэгтийн дагуу нэгтгэж, өдөр бүрийн 09:00 цагт Биеийн тамир, спортын улсын хороонд ирүүлсэн байна.





Удирдамжийн үндсэн зорилго:

Коронавируст халдвар /ковид-19/-өөс сэргийлэх арга хэмжээг зохион байгуулах, биеийн тамир, спортын үйл ажиллагаа үзүүлдэг төрийн болон хувийн хэвшлийн байгууллага, иргэн, хуулийн этгээдийн зөвшөөрөгдсөн үйл ажиллагаанд халдвар хамгааллын дэглэм сахиулах, ажил үйлчилгээг хэвийн явуулах нөхцөлийг бүрдүүлэхэд оршино.

Удирдамжийн хэрэгжилтэд шат шатны БТС-ын байгууллага зөвлөн туслах, мэргэжил арга зүйгээр хангах, хууль хяналтын байгууллагуудтай хамтран ажиллана. Ингэхдээ аймаг, нийслэлийн БТС-ын салбарын төрийн байгууллага нь тухайн нутаг дэвсгэрт үйл ажиллагаа явуулж буй чийрэгжүүлэх бялдаржуулах төв, төрөлжсөн спорт клуб, заал, талбай, цанын бааз, мөсөн гулгуурын талбайн судалгаа, мэдээллийг гаргаж, өдөр бүрийн үйл ажиллагааны тайланг БТСУХ-ны covid19@sport.gov.mn хаягаар ирүүлж ажиллана.

#### Гурав. Үйлчилгээ үзүүлэх зохион байгуулалт

3.1 Чийрэгжүүлэх, бялдаржуулах төв, төрөлжсөн спорт клуб, спорт заал, талбай, цанын бааз, мөсөн гулгуурын талбайн үйлчилгээ, үйл ажиллагаа явуулахдаа тухайн дүүргийн Биеийн тамир, спортын газар, хороонд урьдчилан мэдэгдэж нэг удаад хичээллэх хүний тоо, цагийн хуваарь, багш дасгалжуулагч, байршил, талбайн багтаамжийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг гаргасан байна.

3.2 Ерөнхий боловсролын сургалтын байгууллагын спорт заал, талбайд хичээллэх спортын секц, дугуйлангийн үйл ажиллагаа нь Боловсролын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын шийдвэрээр зохицуулагдана.

3.3 Олон улсын болон дотоодын аймаг, нийслэл, улсын чанартай тэмцээн зохион байгуулах тохиолдолд тухайн зохион байгуулагч нь Улсын Онцгой комисст хүсэлт гаргаж, шийдвэр гаргуулсны үндсэн дээр тавигдах тусгай нөхцөл шаардлагыг ханган зохион байгуулж болно.

3.4 Удирдамжийн 3.1-д заасан үйл ажиллагааг иргэн, аж ахуй, хуулийн этгээд нь үйлчлүүлэгчдийн цагийн хуваарь, бүртгэл судалгааг нарийвчлан гаргаж тайлан мэдээг, тухайн нутгийн биеийн тамир, спортын асуудал хариуцсан байгууллагад өдөр бүр хүргүүлж ажиллана.

3.5 Сэжигтэй болон эрсдэл үүссэн тохиолдолд холбогдох мэргэжлийн хяналт болон эрүүл мэндийн байгууллагад хандана.

#### Дөрөв. Хяналт, хариуцлага

4.1 Энэхүү удирдамжийн хэрэгжилтэд шат шатны Биеийн тамир, спортын байгууллага, хууль тогтоомжоор эрх олгогдсон бусад байгууллага, албан тушаалтан хуульд заасан эрх хэмжээний хүрээнд хяналт тавьж ажиллана.

4.2 Энэ удирдамжийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр шат шатны Биеийн тамир, спортын байгууллага зөвлөн туслах, мэргэжил арга зүйгээр ханган ажиллана.

4.3 Хүний эрүүл мэндэд хохирол учруулсан, учруулах болзошгүй бодит нөхцөл байдал үүсгэсэн тохиолдолд холбогдох хууль журмын дагуу холбогдох хууль хяналтын байгууллагад мэдэгдэж шийдвэрлүүлнэ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО

**Аливаа спортын арга хэмжээ нь Ковид-19 халдвар тархах хамгийн өндөр эрсдэлтэйд тооцогддог.**

1. Орчны төлөвлөлт:
2. Хоорондын зай:
3. Тоглоомын талбай:
4. Маскны хэрэглээ:
5. Бэлтгэлийн түвшин:
6. Хамрах хүрээ:
7. Агааржуулалт:
8. Хэрэглэсэн тоног төхөөрөмж, гадаргуу, хэрэгсэл:
9. Цэвэр гар:
10. Оролцогчдын тоо:
11. Хугацаа:






## ДАСГАЛЖУУЛАГЧДЫН АНХААРАХ ЗҮЙЛ

1. Баг, тамирчидадаа цахим шуудан илгээх, утсаар ярих, хэрэв Таны багийн тамирчин өсвөрийн тамирчин бол түүний эцэг эх, асран хамгаалчидтай холбогдох,
  - а. Аливаа тэмцээн уралдааны зохион байгуулалт нь зөвхөн баг тамирчдыг хамгаалах зорилгыг баримтлан зохион байгуулах тухай мэдээлэл хүргүүлэх
  - б. Баг тамирчдын ар гэртэй холбогдож тухайн тамирчны эрүүл мэндийн талаарх мэдээллийг авах, Ковид-19 халдвар шинжилгээгээр илэрсэн эсвэл шинжилгээний хариу хүлээж байгаа, Ковид-19 халдварын ямар нэг шинж тэмдэг илэрсэн эсвэл Ковид-19 халдвартай, шижилгээний хариу хүлээж байгаа, ямар нэг шинж тэмдэг илэрсэн хүнтэй харилцаанд орсон эсэхийг нягтлах,
2. Баг, тамирчдыг манлайлах. Аливаа тэмцээн, бэлтгэлийн арга хэмжээний үеэр оролцож буй хүмүүсийг маскаа зүүх талаар шаардлага тавих, дасгалжуулагч бүхий л цаг үед маскийг зөв зүүх,
3. Хамгийн багадаа 60 хүртэлх хувийн спиртийн орцтой гар ариутгагчаар хангах
4. Баг, тамирчдыг бүхий л цаг үед ханилгах, найтаахдаа хаалт хэрэглэхийг зөвлөх. Шүлс, нус, цэр гаргахыг бүхий л цагт хориглох,
5. Баг, тамирчдын гишүүд хоорондын зайг бүхий л цагт барихыг дэмжих, Шаардлагатай тохиолдолд тухайн заал, талбайн шалан дээр хүн хоорондын зайг тодорхойлсон тэмдэглэгээг хийх,
6. Бэлтгэлийн үеэр зөвхөн бие даасан, ганцаарчилсан бэлтгэл, дасгалжуулалтын арга барилыг баримталж, олон хүний бөөгнөрөлийг үүсгэхгүй байх,
7. Спортын удирдах байгууллагатай холбогдож, тухайн заал, талбайн ариутгал, цэвэрлэгээний зааварчилгааг дагаж байгаа талаар нягтлах,
8. Тухай заал, талбай, тоног төхөөрөмжийг хэрэглэсний өмнө болон дараа нь байнга ариутган, цэвэрлэх,

# Эрсдэл өндөр

- Сагсан бөмбөг
- Бокс
- Хөл бөмбөг
- Хоккей
- Халз тулааны төрөл
- Регби
- Бөх



## Дунд зэрэг эрсдэлтэй

- Хөл бөмбөг
- Футзал
- Пейнтбол
- Волейбол
- Усан поло
- Тэргэнцрийн сагсан бөмбөг

# Бага эрсдэлтэй

- Байт харваа
- Бадминтон
- Бейсбол
- Загасчлал
- Боулинг
- Авиралт
- Кросс
- Дугуйн
- Теннис
- Хөнгөн атлетик
- Буудлага
- Хүндийн өргөлт
- Гимнастик
- Морь унах
- Мөсөөр гулгах
- Дарвуулт завь,
- Сэлүүрт завь
- Скейтбординг
- Софтбол
- Цанаар гулгах
- Усанд сэлэлт

Бага эрсдэл

Өндөр эрсдэл



Гэртээ дасгал  
сургууль хийх



**Багийн бэлтгэл**



Баг доторх  
тэмцээнийг  
зохион байгуулах




Өөрийн оршин суудаг  
газрын багтай  
тэмцээнд оролцох



Бусад хот, бүс нутгуудад  
болох тэмцээнд багаараа  
оролцох



# Хамтын ажиллагаа





ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО**

**Байгууллага мэдээлэл**

Аймаг, нийслэл, дүүрэг .....				Байгууллага		Хүснэгт 1
№	Овог нэр	Албан тушаал	Утасны дугаар	Мэйл хаяг	Ажиллах цагийн хуваарь	чиг үүрэг
1						
2						
3						
4						
5						
6						
7						
8						
9						

Тайлбар: "чиг үүрэг" хэсэгт байнгын мэдээ ирүүлэх, цахимаар тогтмол холбогдох 1-2 хүнийг "+ " тэмдэг бичнэ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ  
**БИЕЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО**

"COVID19" цар тахлын үеийн удирдамжаар ажиллах байгууллагын мэдээлэл																											
Аймаг, Нийслэл, дүүрэг ..... БТСГ, хорооны .....байгууллага																											
№	Аж ахуйн нэгжийн нэр	Үйлчилгээний төрөл	Холбогдох утасны дугаар	Хариуцах ажилтан	Заал, талбайн хэмжээ м2		Хичээллэгчдийн тоо			Багш нарын тоо			Эмч		Ажилчдын тоо	Нийт албан хаагчдын тоо		Зай хоорондын тэмдэглэгээ хийсэн эсэх	Амны хаалт, 1 удаагийн бээлий хэрэглэдэг эсэх	Дасгалын тоног, төхөөрөмж бүрт гар халдваргүй жилт, ариутгалын бодис, алчуур байршуулс	Халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээ, агаар сэлгэлт 2 цаг тутамд хийдэг эсэх	Халуун хэмжигч, QR код уншигчтай эсэх	Бүртгэлийн дэвтэр хөтөлж байгаа эсэх				
					Дотор	Гадна	1 цагт	1 өдөрт	Нийт	Багш	Дасгч	А/зүйч	Үндсэн	Гэрээт		Нийт	Үүнэ эс эм										

Тайлбар: "Хариуцах ажилтан" баганад холбоо барих, мэдээ ирүүлэх хүнийг бичнэ. Дээрх үзүүлэлтээс гадна ЗГ - ын 2021 оны 45 -р тогтоолын хавсралт, УОК- ын даргын 2021 оны 18 -р тушаалаар баталсан Түр журмыг хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавьж, зөвлөмж өгөх ба бусад хууль, журам, тогтоол шийдвэрийн дагуу нэмэлтээр хяналт хийнэ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ТОХИРУУЛАГЧ АГЕНТЛАГ

**БИЕИЙН ТАМИР, СПОРТЫН УЛСЫН ХОРОО**

<b>"COVID19" цар тахлын үеийн удирдамжаар ажиллах байгууллагын мэдээлэл ирүүлэх хүснэгт</b>																					
Аймаг, Нийслэл, дүүрэг ..... байгууллага																					
№	Аж ахуйн нэгжийн нэр	Үйлчилгээний төрөл	Холбогдох утасны дугаар	Хариуцах ажилтан	Заал, талбайн хэмжээ м2		Хичээллэгчдийн тоо			Зай хоорондын тэмдэглэгээ хийсэн эсэх	Амны хаалт, 1 удаагийн бээлий хэрэглэдэг эсэх	Дасгалын тоног, төхөөрөмж бүрт гар халдваргүйжилт, алчуур байршуулсан эсэх	Халдваргүйжүүлэлт, цэвэрлэгээ, агаар сэлгэлт 2 цаг тутамд хийдэг эсэх	Халуун хэмжигч, QR код уншигчтай эсэх	Бүртгэлийн дэвтэр хөтөлж байгаа эсэх	Ажилтан, албан хаагчдыг цахимаар ажиллах нөхцөл бүрдүүлсэн эсэх	Анхны тусламжин иж бүрдэл, цэвэрлэгээн ний цомог, халдваргүйжүүлэх бодис бүхий тусгаарлах өрөө	Түр тусгаарлах ажрыг зохион байгуулах ажилтан томилсон эсэх	Тайлбар		
					Дотор	Гадна	1 цагт	1 өдөрт	Нийт												
1																					
2																					
3																					
4																					
5																					
6																					
7																					
8																					
9																					
10																					
11																					
12																					
13																					
14																					
15																					

Тайлбар: Үзүүлэлтийн харгалзах нүдэнд Шаардлага хангасан бол + /нэмэх/, Хангаагүй бол - /хасах/ тэмдэг бичнэ. Тайлбар баганад хасах тэмдэг авсан шалтгаан, зөрчлийг арилгах талаар бичнэ. "Хариуцах ажилтан" баганад холбоо барих, мэдээ ирүүлэх хүнийг бичнэ. Дээрх үзүүлэлтээс гадна ЗГ - ын 2021 оны 45 -р тогтоолын хавсралт, УОК- ын даргын 2021 оны 18 -р тушаалаар баталсан Түр журмыг хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавьж, зөвлөмж өгөх ба бусад хувь, журам, тогтоол шийдвэрийн дагуу

**Анхаарал хандуулсанд баярлалаа.**

